ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
"ХОТ, ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ" ОНӨААТҮГ

2026 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Нотлох баримт |
|---|---|---|---|---|---|
| ЗГ-ын албан даалгавар | | | | | |
| 1 | 1 | ЗАСГИЙН ГАЗРААС ШУУРХАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-07-25 Дугаар 2025_04 | 1.2.. төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад; | Тайлант хугацаанд буюу 2026 оны 01 дүгээр улиралд нэг албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн. Тухайн орон тоон дээр нөхөн томилолт хийгдээгүй болно. |  "ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ" ОНӨААТҮГ<br>ДАРГЫН ТУШААЛ<br>2026 оны 02 сарын 09 өдөр Дугаар Б/08 Улаанбаатар хот<br>Г.Уранбайгалыг ажлаас чөлөөлөх тухай<br>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дах заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9 дах заалт, 79 дүгээр зүйлийн 79.2 дахь хэсэг, 82 дугаар зүйлийн 82.1.4 дэх заалт, 82.5 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.8.7, Хөдөлмөрийн дотоод журмын 6.3, 11.14-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:<br>1.Тус институтийн Хяналт, судалгаа мониторингийн хэлтсийн дарга Гончигийн Уранбайгал нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосноор хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болгох хүсэлт гаргасан тул 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон хөдөлмөр эрхлэлтийн харилцаат цуцалж үүрэг ажлаас нь чөлөөлсүгэй. |
| | 2 | | 1.3.. иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3 | | 1.4.. төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад; | Байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 03 ны өдрийн А/27 дугаар тушаалаар Байгууллагын даргын дэргэд Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулан ажиллаж байна. | “ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ” ОНӨААТҮГ<br>ДАРГЫН ТУШААЛ<br>2024 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/27 Улаанбаатар хот<br>Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай<br>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 13.2 дахь хэсэг, Монгол Улсын ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.2, 2.4, 2.7, 3.8, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.8.7, Хөдөлмөрийн дотоод журмын 6.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:<br>1.“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын даргадэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг байгууллагын албан хаагчдаас өгсөн нууц санал хураалтыг үндэслэн хавсралтаар баталсугай.<br>2.Байгууллагын даргадэх Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн даргаар сонгогдсон ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг үзэгдлийг таслан зогсоох, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд даалгасугай.<br>3.Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улирадд нэг удаа урамшуулал олгохыг Ерөнхий нягтлан бодогч О.Ямбасүрэнд зөвшөөрсүгэй.<br>4.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, менежментийн хэлтэс (Х.Мөнхнаран)-т даалгасугай.<br>5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/43 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.<br>ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Р.АМАРТҮВШИН<br>1760010183 |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, МЕНЕЖМЕНТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Х.МӨНХНАРАН

БОЛОВСРУУЛСАН:
ОЛОН НИЙТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.БУЯНХИШИГ